



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/422

Чойбалсан

Г Нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 03 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 6.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг үзүүлэх "Нутгийн ирээдүй" төслийг хэрэгжүүлэх тухай 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Нутгийн ирээдүй" сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2025 онд оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдах боломжтой орон нутагт нэн хэрэгцээтэй мэргэжлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Орон нутагт нэн шаардлагатай, тус тэтгэлэгт хамрагдах боломжтой мэргэжлийн жагсаалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/421 дүгээр захирамжаар баталсан "Нутгийн ирээдүй зорилтот төслийн хүрээнд оюутныг сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулах журам"-ын дагуу олон нийтэд нээлттэй мэдээлж, тэтгэлэгт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн оюутны хүсэлтийг хүлээн авч сумын Засаг даргын зөвлөл болон тухайн агентлаг, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн сонгон шалгаруулж, шийдвэр, холбогдох материалыг хуралдааны тэмдэглэлийн хамт 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэхийг сумын Засаг дарга нарт, мөн дээрх журамд заасан байгууллагуудын удирдлагад тус тус даалгасугай.

3.Сумын Засаг дарга нар болон дээрх журамд заасан агентлаг, байгууллагаас ирүүлсэн оюутны материалыг аймгийн Засаг даргын 2022 оны А/422 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн хуралдаанаар 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэлэлцүүлэн баталгаажуулж, тэтгэлэгт хамрагдах оюутнуудтай байгуулах гэрээний төслийг боловсруулан танилцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (У.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ



My computer D/ Zakhiramj

2125011072

Аймгийн Засаг даргын 2025 оны
08 дугаар сарын 11-ны өдрийн
А/Н/22 дугаар захирамжийн хавсралт



“НУТГИЙН ИРЭЭДҮЙ ЗОРИЛТОТ ТӨСӨЛ”-ИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН
ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ОРОН НУТАГТ НЭН
ШААРДЛАГАТАЙ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

№	Мэргэжил
1	Нийгмийн ажилтан
2	Хүний их эмч
3	Бага эмч
4	Сувилагч
5	Лаборант
6	Эх баригч
7	Нягтлан бодогч
8	Бага ангийн багш
9	Англи хэлний багш
10	Эрүүл мэндийн багш
11	Биологийн багш
12	Технологийн багш
13	Математикийн багш
14	Физикийн багш
15	Бүжгийн багш
16	Хөгжмийн багш
17	Монгол хэл, уран зохиолын багш
18	Агрономич
19	Сургуулийн өмнөх боловсролын багш
20	Мал зүйч
21	Малын их эмч
22	Байгаль хамгаалагч
23	Хүрээлэн буй орчныг хамгаалах технологи
24	Газар зүй зохион байгуулалт
25	Геодези
26	Сэтгэл зүйч
27	Хоол зүйч
28	Эрх зүйч
29	Сантехникийн инженер
30	Архитектор
31	Гидротехникийн инженер
32	Авто зам, гүүрийн инженер